

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ  
ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
4 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-20
<b>2</b>	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл</b>	21-83
	<b>1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 10 гишүүн 2020.04.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	22-38
	<b>2.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	38-48
	<b>3.Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 02 дугаар дүгнэлт</b>	49-51
	<b>4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 7 гишүүн 2020.04.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	51-57
	<b>5.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 14 гишүүн 2020.04.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	57-73
	<b>6.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2020.04.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	73-77
	<b>7.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлж, томилох тухай асуудал</b>	77-82
	<b>8.Ажлын хэсэг байгуулах тухай /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд/</b>	82-83

## ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

***Хоёр.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг, мөн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, Хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга С.Сүхбаатар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн зөвлөх Г.Сувд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ц.Болормаа, Б.Хатантуул, референт Б.Золбоо, Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Ж.Батзандан, Л.Болд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ц.Мөнх-Оргил, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Ж.Батзандан нар үг хэлэв.

**С.Бямбацогт:** Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.*

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Дараагийн асуудал. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэе ээ.

Ажлын хэсгээ оруулаарай.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн хийнэ ээ.

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Бямбацогт, Нямбаатар, Мөнх-Оргил, Амарзаяа, Ганболд, Батзандан, Лүндээжанцан, Баатарбилэг нарын 9 гишүүн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсрууллаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь нийтлэг үндэслэл, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүү, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг хот, тосгонд шилжүүлэх, нэгжийн удирдлага бусад байгууллагатай харилцах гэсэн 6 бүлэг, орон нутгийн чиг үүрэг, нутгийн өөрөө удирдлага, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж дэх төрийн удирдлага гэсэн 3 дэд бүлэг 81 зүйлээс бүрдэж байна аа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн онцлогийн талаар та бүхэнд дараах байдлаа тодорхойлж байна аа. Үүнд:

1.Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зарчим, журмыг шинээр зохицуулах бөгөөд үүнтэй уялдаатайгаар нэгж, байгууллагад харгалзах үзүүлэлтийг шинээр тодорхойлж, нэгжийг өөрчлөх саналыг Засгийн газар боловсруулж, иргэдээс санал авах ажлыг иргэдийн төлөөлөгчдийн хурал зохион байгуулах үүрэг хүлээх бөгөөд санал авах үр дүнг тооцох журмыг Улсын Их Хурал тогтоохоор хуульчиллаа.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоныг өөрийн удирдлагын хүрээнд эдийн засаг нийгэм, аж ахуйн асуудлыг түлхүү шийдвэрлэх орон нутгийн корпорац хэлбэрт шилжих эрх зүйн үндэс бий болгохтой холбогдуулан хот, тосгон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын засаг захиргааны шинжтэй зарим чиг үүргийг хэрхэн яаж шилжүүлэх, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлага, нутаг дэвсгэр дэх хот, тосгоны өөрийн удирдлагатай харилцах суурь зарчмуудыг энэ хуулиар тогтоолоо. Үндсэн хуулийн үзэл санааны дагуу нутгийн удирдлагын хөгжлийг бэхжүүлэх асуудал энэ хуулийн амин чухал асуудлын нэг юм аа. Энэ хүрээнд орон нутгийн удирдлагын чиг үүргийг

тодорхойлох, ийм төрлийн чиг үүрэг орон нутгийн хурал бие даан шийдвэрлэх бөгөөд төрөөс үүнд оролцохгүй, мөн түүнчлэн төрөөс орон нутгийн удирдлагад шилжүүлж болох болон шилжүүлж үл болох чиг үүргийн жагсаалтыг хуулиар тодорхойллоо.

Орон нутгийн бие даасан байдлын хүрээнд нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор иргэдийн шууд удирдлагын хэлбэр болох иргэдийн нийтийн хурлын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг тусгайлан зохицуулахын сацуугаар бусад хэлбэрийг ч хуульчиллаа. Орон нутгийн бие даалгах, эдийн засаг нийгмийн асуудлаа шийдвэрлэх, эдийн засаг нийгмийн цогцолбор болгоход анхаарч төсөв, татварын орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх, сум, дүүргийн өмчийг бий болгох, орон нутгийн хөгжилд нутгийн иргэдийн санаачилгыг нэмэгдүүлэхэд анхаарч хуулийн төслийг боловсрууллаа.

Эрхэм Байнгын хорооны гишүүд та бүгдийг хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг танилцуулъя. Ганзориг Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Товуусүрэн Улсын бага хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан, Хатанбаатар Ардын их хурлын депутат, Улсын бага хурлын гишүүн асан, Лувсанжав Монгол улсын гавьяат хуульч, Бямбажаргал Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, дэд профессор, хууль зүйн ухааны доктор, Сүхбаатар Дундговь аймгийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн дарга, Сувд Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн зөвлөх гэсэн ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна аа.

Бусад нь орж болохгүй болохоор зарим нь ороогүй байх, өөр танхимд сууж байгаа байх, нөгөө танхимд багтахгүй болохоор. Товуусүрэн гуайг оруулчаарай.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Болд гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

**Д.Эрдэнэбат:** Би энэ хуулийг Үндсэн хуулийг дагалдаж, өөрчлөлтийг дагалдаж шинэчлэн найруулагдаж орж ирж байна аа гэж харж байгаа. Үндсэн хууль дээр заагдсан нэг том онгорхой хагас порчик нь онгойсон зүйл болбол орон нутгийн бие даасан байдал, төсөв санхүү, зарим нэгэн татварыг тогтоох эрхийн тухай байгаа юм аа. Тэгээд бид энэ боломжийг маш зөв ашиглах ёстой байсан болов чиг энэ зорилгодоо энэ хуулийн төсөл өөрөө огт хүрч чадахгүй байгаа юм. Ерөөсөө хуулийнх нь зорилго нь өөрөө агуулгын хувьд зүгээр л иргэдийн орон нутгийн иргэд өөрийнхөө төлөөллийг байгуулж болно, төлөөлөл нь болбол засаглалыг хэрэгжүүлэх ийм эрх үүрэгтэй ажиллана гэснээс өөр зүйл байхгүй байгаа юм. Ер нь болбол орон нутгийн хөгжлийг бид нар юу гэж харах вэ гэхээр орон нутгийн засаг захиргааны үүрэг болбол тэр хот байна уу, аймаг байна уу, сум байна уу, дүүрэг байна уу, ялгаа байхгүй. Ерөөсөө л тухайн нутаг дэвсгэртээ оршин сууж байгаа иргэдийнхээ сайн сайхны төлөө, эрүүл мэндийн төлөө, эдийн засгийн баталгааг хангахын төлөө, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй байлгахын төлөө л зорилго шүү дээ. Бид ингээд л угжирч ирсэн олон жил энэ захиргааны арга барилаасаа салахгүй хууль, өнөөдөр яг энэ арга барилыг бүр гүнзгийрүүлж орж ирж байгаа. Гүнзгийрүүлэх гүнзгийрүүлэхдээ орон нутгийн бие даасан байдал, иргэдийн төлөөлөгчдийн өөрийгөө удирдах байгууллагын хүчин чадавхыг бүр сулруулж орж ирж байгаа гэж харж байгаа. Тэр байтугай зарим нэгэн засаг даргын

томилгоо, шат шатны засаг даргын томилгоонд орон нутгийн өөрөө бие даасан байгууллагын удирдлагыг засаг даргыг сонгоход хүртэл нөлөөлөх хэмжээний ийм хуулийг оруулж ирж байгаа байхгүй юу. Яагаад ингээд нэг босоо байдлаасаа ингээд татгалздаг, дургүй улсууд байдаг юм бэ. Босоо байдлыг өөгшүүлэх дуртай улсууд байдаг юм бэ гэж би эсрэгээр нь хэлье, тэгвэл. Тэгэхээр энэ зүйл дээр энэ хууль бол үнэхээр нийцэхгүй байгаа. Би үзсэн. Би ажлын хэсгийнхэн та нарыг хэдүүлээ санал солилцъё гэсэн, үүнийг авч хэлэлцээгүй ээ. Уулзъя гэхээд алга болсон. Бодвол Эрдэнэбаттай битгий уулз, ингээд кнопчихъё гэж бодсон юм байгаа биз. Кнопдоно оо, та нар үүнийг. Кнопдоод дуусгана, мэдэж байна. Тэгэхдээ энийг дараагийн Их Хурал тэртээ тэргүй өөрчилнө. Энэ бол явахгүй. Бид нар орон нутгаа хөгжүүлбэ гэж ярьчихаад орон нутгийн бүх эрх мэдлийг төвлөрүүлдэг зарчим энүүгээр илүү баталгаажиж байгаа нь энэ хууль явахгүй гэдгийг би хэлж байгаа юм. Орон нутаг өөрийн бие даасан байдлыг хангахад эдийн засгийн менежментээ өөрсдөө явуулдаг байх ёстой. Нийгмийнхээ үйлчилгээний хүртээмжийн санхүүг өөрсдөө босгодог байх ёстой. Өөрийн удирдлагын дагуу өөрсдийнхөө үл хөдлөх хөрөнгийн болон татварын зохицуулалтыг өөрөө бие даан хийх үүргийг хүлээдэг байх ёстой. Үндсэн хуулиар хүмүүсийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгийн түрүүнд орон нутгийн засаг захиргаа хангах үүргийг хүлээх ёстой. Харамсалтай нь энэ хуульд тийм зүйл тусаагүй байгаа. Тийм учраас би энэ хуулийг болбол эхнээс нь дэмжихгүй. Санал хураалтад орохгүй. Яагаад гэвэл энэ буруу хууль болж байгаа. Би энийгээ харин шуудхан хэлчихье гэж бодож байна.

**С.Бямбацогт:** Асуулт хариултын цаг явж байгаа. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

**Д.Тогтохсүрэн:** Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя аа. Эрдэнэбат гишүүн ээ, Та тавхан минут суугаад сонсчих. Энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бол 1 дүгээрт энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой.

2 дугаарт энэ хуулийн төслийг 2018 оноос хойш судалж, боловсруулж байгаа юм аа. Энэ хуулийн төсөлд нутгийн удирдлагын чиглэлээр ажилладаг бүх эрдэмтэн, судлаачид, орон нутгийн удирдлагууд, орон нутагт ажилладаг хүмүүс бол олон удаа оролцсон ийм хуулийн төсөл байгаа. Хуулийн төслийн хамгийн том концепт бол сая Эрдэнэбат даргынхаас эсрэг юм байгаа юм аа.

1 дүгээрт бол бид нар аль болохоор орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд энэ хуулийн хамгийн том концесс оршиж байгаа гэж бодож байгаа юм. Эрх мэдлийн хүрээнд 3 том асуудал энд байгаа. 1 дүгээрт, хамгийн чиг үүргийн асуудал байгаа, өмнө нь аймаг, сум, нийслэл, дүүргийн удирдлагуудын чиг үүрэг бүгд давхацсан байсан. Одоо энэ чиг үүргүүдийг нэгж тус бүрээр нь салгаж аль болохоор иргэндээ ойр байх нэгжид чиг үүргийг өгөхөд чиглэгдсэн ийм хуулийн төсөл байгаа.

2 дугаарт нь санхүү, төсөв, өмчтэй холбоотой хэд хэдэн том юм байгаа Эрдэнэбат дарга хамгийн сүүлийн хувилбарыг уншаагүй юм болов уу л гэж бодоод байна. Тухайлбал бид нар суманд төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж өгсөн, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тодорхой хувийг орон нутагт өгөх, хүн амын орлогын албан татварын 100 хувь суманд өгөх, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг өгөх, дээр нь малын тоо, толгойн албан татварыг суманд өгөх

мэтчилэнгээр сум, дүүрэг рүү энэ татварын орлогыг нь нэмэгдүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн өөрчлөлтүүдийг хийж өгсөн байгаа.

3 дугаарт нь орон нутагт ажиллаж байгаа энэ орон нутгийн боловсон хүчний эрх мэдлийг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулж өгсөн байгаа. Энэ талаар болбол би тайлбарлахаас илүүтэйгээр би Ганзориг багш эд нарыг нэлээд тодорхой тайлбарлачихвал зөв болов уу гэж бодож байна.

Засаг даргатай холбоотой асуудал байгаа, Эрдэнэбат гишүүн ээ. Энэ олон үе дамжиж яригддаг асуудал байгаа юм аа. Засаг даргатай холбоотой асуудал. Монгол Улс болбол 1 дүгээрт бол нэгдмэл улс аа, 2 дугаарт бол засаг дарга болбол Үндсэн хуульд зааснаар засаг даргын төлөөлөгч байгаа юм аа, 3 дугаарт нь өнөөдөр манай орон нутагт гажуудаад байгаа нэг юм болбол иргэдийн хурлын төлөөлөгчдийн барьцаанд засаг дарга орчхоод байгаа юм аа. Ийм учраас орон нутгийн засаглалын асуудал үнэхээр цаашдаа хомсдолд ороод байгаа юм. Ийм учраас энэнээс гарах арга нь болбол бид нар засаг даргыг дээд шатны засаг дарга буюу багийн даргыг сумын дарга, сумын даргыг аймгийн засаг дарга, аймгийн засаг даргын Ерөнхий сайд томилохгүй гэхэд санал оруулах нэг ийм зүйлийг энэ хуульд шинээр оруулж ирсэн. Тийм. Хуулийн төсөл гэдэг болбол хуулийн төсөл. Үүнийг сайжруулахад Их Хурлын гишүүн бүр одоо оролцож үүрэг хүлээх ёстой гэж би боддог юм.

Би нэг ийм тайлбар өгье, тэгээд Бямбацогт дарга аа энэ орон нутгийн эрх мэдлийг өмнөхөөс нь яаж нэмэгдүүлсэн талаар энэ дэд ажлын хэсгийнхнээс тайлбар өгвөл би зөв байх аа гэж ингэж бодож байгаа юм.

**С.Бямбацогт:** За баярлалаа. Манай хууль санаачилсан гишүүд Мөнх-Оргил гишүүн бас бусад гишүүд нэмэлт хариулт өгч болно. Дэд ажлын хэсэг Ганзориг багш 3 дугаар микрофон.

**Д.Ганзориг:** За баярлалаа. Тэгэхээр нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийн бид нар хамгийн түрүүнд энэ хуулийн зорилго өөрөө юу байх юм бэ гэдэг ийм шинэ томъёолол оруулж ирсэн байгаа. Тэгэхээр манай улс бол 1 талаас Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлд зааснаар нэгдмэл улс гэдэг нэг ийм хатуу зарчим байна. 1 хууль 1 тогтолцоо, хяналт шалгалт гэсэн нэг ийм зүйл байна. Нөгөө талаасаа бол юу вэ гэхээр тодорхой нэг улсыг бүрдүүлж байгаа тодорхой нэг засаг захиргааны нэгжид өөрийн удирдлага буюу иргэд ажил хэргээ өөрсдөө эрхэлж явуулах асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ 2-ыг яаж балансжуулах вэ гэдэг бол энэ хуулийн ерөөсөө амин сүнс юм байна лээ. Бусад орнууд ч гэсэн яг энийг л ерөөсөө олж үздэг энэ нутгийн удирдлага гэдэг энэ асуудал дээр байгаад байгаа. 1 дэх хэлэх гэсэн зүйл бол энэ байна.

2 дугаарт бол судлаачийн хувьд бид 1992 оны нутаг дэвсгэрийн нэгжийн хууль, 2006 оны нутаг дэвсгэрийн нэгжийн хууль гэсэн ийм 2 хуультай явж ирсэн. Гэхдээ хараад байхад энэ 2 хууль маань Үндсэн хуулийн суурь зарчмуудыг бэхжүүлж чадсан уу гэвэл үгүй гэж хардаг юм аа. Тийм учраас энэ хууль бол өнөөдөр нэмэлт, өөрчлөлт бөгөөд 1992 оны Үндсэн хуулийн суурь зарчмууд гэсэн энэ 2 дээр тулгуурлаж боловсрогдсон ийм хууль гэж бодож байгаа юм аа.

Нэгжийн удирдлагын хувьд бол төрийн удирдлага нэг талаасаа байна, энэ бол төрийн хууль тогтоомжийг биелүүлэх ажлын асуудал байж байгаа, нөгөө талаасаа бол юу вэ гэхээр нэгж дэх өөрийн удирдлагын асуудал байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр нутгийн удирдлагатай холбоотой нэг түүгээд үзэхэд нэг 300 орчим хууль байна. Тэгэхээр энэ 300 орчим хуулийг шүүгээд үзэхэд яг өнөөдрийн хүчин төгөлдөр байгаа хуулиудын хувьд бол бүх ажил хэргийг төрийн чиг үүрэг гэдэг байдлаар тодорхойлсон байгаа юм, бүх ажил хэргийг, энэ бол бүр хамгийн тод жишээ бол юу байдаг вэ гэхээр Төсвийн хууль байгаа. Төрийн ажил үүргийг орон нутагт хэрэгжүүлэх гэдэг утгаар хийсэн ийм хуулиуд манай өнөөгийн хүчин төгөлдөр байгаа орчин. Тийм учраас бид нар бол яасан бэ гэхээр энэ төрийн чиг үүрэг, төрийн ажил хэрэг мөн орон нутгийн ажил хэрэг гэж ийм 2 ойлголт байх юм байна аа гэдэг энэ зүйлийг бол энэ хуулиар анх удаагаа дэвшүүлж байгаа. Тэгэхээр энэ талаасаа харах юм бол харин ч одоо магадгүй нутгийн өөрийн удирдлагыг орон нутгийг нэлээн тийм дэмжсэн хууль байгаа болов уу гэж ингэж харж байгаа юм.

Үүний 2 том илэрхийлэл байна. Тэр бол юу вэ гэхээр 1 дүгээрт түрүүн Тогтохсүрэн гишүүн хэлсэн. Орон нутгийн чиг үүргийн асуудал байна. Энэ дээр одоо манай гаднын хөрөнгө оруулагч нарын судалгааны зүйлүүд дээр бол байнга харагддаг зүйл бол юу вэ гэхээр танай улсад бол төвлөрөл асар их хэмжээгээр байна. Тэгэхээр энэ төвлөрлөө сааруулаач ээ, аль болох иргэддээ ойрхон энэ нэгжүүдэд чиг үүргийг хуваарилаач ээ, энэ чиг үүрэг гэдэг энэ ойлголтоо бий болгооч ээ гэдэг ийм зүйлийг бол байнга дэвшүүлдэг. Тэгэхээр энэ талаасаа бол юу вэ гэхээр бид нар төрийн ажил хэрэг, орон нутгийн ажил хэрэг гэдэг энэ 2-ыг бол салгасан ийм зүйл байгаа. Тэгэхээр энэ бол магадгүй харин бүрэн дүүрэн биш байж магадгүй. Гэхдээ яг өнөөгийн байдлаар бол харьцангуй гучин хэдэн чиг үүргийг бол тодорхойлж ингэж гаргасан ийм зүйл байгаа юм.

2 дугаарт бол юу вэ гэхээр орон нутгийн нэгэнт чиг үүрэг тодорхой ажил үүргийг хуваарилж байгаа учраас энэнтэй холбоотой санхүүжилтийн асуудлууд байна. Тэгэхээр улс орон бол тодорхой нэгжийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээдэг. Тэгэхээр 1 талаасаа бол юу вэ гэхээр ... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Батзандан гишүүн асуултаа асууя.

**Ж.Батзандан:** За засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байгаа. Ажлын хэсэгт ШИНЭ нам, ШИНЭ эвсэл бас ороод ажиллаж байгаа. Энэ бол Монгол Улсын 152 хороо, 330 сум, 21 аймаг, 9 дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын систем ямар байх вэ гэдэг асуудлыг ярьж байгаа юм аа. Бид өнгөрсөн 30 жилийнхээ алдааг засах гэж л энэ хуулийг оруулж ирж байгаа. Шинэ үндсэн хуультайгаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулж байгаа. Тодорхой хэдэн зүйлийг хэлье.

Санхүүжилт төсвийн асуудлыг бид маш тодорхой харж тусгаж өгөх ёстой юм аа. Улаанбаатар хотын энэ 152 хороо дээр төсвийн асуудал бол бүрэн шийдэгдээгүй байгаа, төсвийн эрх мэдэлгүй баахан хороодтой. Дүүргүүдийн асуудал ч маш хүндрэлтэй. Нийслэлээс шууд хамааралтай, 9 дүүрэгтэй. Бие даасан төсөвтэй 1 ч дүүрэг бараг байхгүй. Ийм л нөхцөл байдлын дундуур 30 жил явж ирлээ. Аймаг болон сумын нөхцөл байдлыг бид бас бүгдээрээ мэдэж байгаа. 1 талаас эрх мэдлийг орон нутагт өгөхгүй гэж өгөөгүй мэт харагдаж байгаа боловч олон сумууд дээр сумынх нь засаг дарга нь сумынхаа газар нутгийг лиценз хэлбэрээр өгчихсөн, авлига албан тушаалын гэмт хэргийг цэцэглүүлчихсэн тууж явна. Иргэддээ худлаа хэлдэг, сумын олон арван засаг даргатай, лицензийг дээрээс өгсөн гэж худлаа хэлдэг, сумын иргэдийн хурлын зөвшөөрөлгүйгээр аймгийн иргэдийн хурлын зөвшөөрөлгүйгээр лиценз олгох ямар ч боломжгүй. Ийм



уялдаагүй системээр 30 жил явж ирсэн учраас Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай гэж бид харж байгаа.

Би Баянзүрх дүүргээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн. Ерөнхийдөө 9 дүүрэг дээр тулгамдаж байгаа асуудал Баянзүрх дүүрэг дээр яг адилхан байгаа. Монгол Улсын хамгийн том засаг захиргааны нэгж Баянгол дүүргээс 2 дахин том, Чингэлтэйгээс 3 дахин том, гэсэн хэдий ч Баянзүрх дүүргийн ард түмэнд үйлчилдэг Тамгын газрынх нь ажилтнуудын тоо нь яг адилхан. Ийм маягаар засаг захиргаа удирдлагын нэгжийн хуулийн цоорхойгоос болж Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг бол үндсэндээ хотын хөдөө болж хэлмэгдсэн дүүрэг болж байгаа юм аа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Баянзүрх болон Сонгинохайрхан, Дархан, Эрдэнэт гэх мэт засаг захиргааны нэгжийн томоохон реформыг хийх гэж энэ хуулиудыг гаргаж байгаа гэж би ойлгож, ажлын хэсэгт орж ажиллаж байгаа юм аа.

Баянзүрх, Сонгинохайрхан, Улаанбаатар хотод хийх засаг захиргааны шинэчлэлийн реформ цаг хугацааны хувьд хэзээ хэрхэн өрнөх вэ гэдгийг ажлын хэсгийн дарга Тогтохсүрэнгээс бас асууж тодруулъя гэсэн хүсэл байна аа. Хуулийг дэмжиж байгаа, ажлын хэсэгт ШИНЭ нам орж ажиллана аа.

**С.Бямбацогт:** За баярлалаа. 2 хууль санаачлагч хоорондоо асуугаад хариулаад байна шүү дээ, одоо тэгээд. Тогтохсүрэн гишүүн, хууль санаачлагч, Батзандан гишүүн бас хууль санаачлагч.

**Д.Тогтохсүрэн:** За баярлалаа, Батзандан гишүүний асуултад хариулъя аа.

1 асуудал бол үнэхээр байгаа. Хуулийн төсөл дээр болбол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар буюу ажлын албаны бүтэц орон тоог засгийн газар батална аа гэсэн энэ хуульд бол ийм л заалт байгаа юм. Цаашдаа болбол харин нэгээр хэлэлцүүлгийн явцад энэ хүн амын тоо, засаг захиргааны нэгжийн бүтцээс хамааруулж орон тоог нэмэгдүүлэх асуудал үнэхээр байгаа юм аа. Энэ чиглэлээр нь би явцын дунд одоо ажиллах боломжтой гэж бодож байгаа юм.

Энэ гурван асуудал хамт одоо энэний дараа 2 асуудал байгаа юм аа. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хууль одоо ингээд ороод ирчхэж байгаа юм, үүний дараа удахгүй бид мөн энд ажиллаж байгаа энэ багийнхан, дэд ажлын хэсгийнхэн, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн боловсруулчихсан бэлдээд санал авахаар Засгийн газарт өгчихсөн байгаа.

Энэ хуулийн дараа энэ хуульд нийцүүлж Монгол Улсын Хот, тосгоны асуудлууд орж ирэх юм аа. Энэ хүрээнд улсын зэрэглэлтэй хот, аймгийн зэрэглэлтэй хот асуудлуудыг ярина аа. Энэ хүрээнд нийслэлийн дүүргүүдийг цаашдаа бие даасан хот байлгах тухай асуудлуудыг ярих юм аа. Ийм 2 хуулийн шинэчлэл нь хийгдэж байж дараа нь энэ асуудлууд гарч ирнэ ээ гэж бид нар тооцож энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг болбол хамтад нь уялдаатайгаар боловсруулсан байж байгаа гэдгийг би бас хэлье ээ. Ганзориг багш болон Мөнх-Оргил гишүүн, Амарзаяа гишүүн, Ганзориг багш энэ манай ажлын дэд хэсгийнхэн хариулт өгвөл энэ дээр тодорхой юм өгөх байх аа гэж би бодож байна.

**С.Бямбацогт:** Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье, хууль санаачлагч нэмэлт хариулт.

**Ц.Мөнх-Оргил:** Үндсэн хуулийн жаран нэгийн дөрөв дээр ингээд заачихсан юм аа, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно гээд энийг нь бид нар хуульдаа суулгасан. Тэгэхдээ энийг ингэж ойлгомоор байгаа юм аа, 1 бүрчлэн гэдэг бол бүгдийг нь нэг нэгээр нь, 1 маягаар гэдэг нь бол манайхны ойлгоод байгаа шиг бүгдийг нь адилхан тоогоор ч байдаг юм уу, орон тоог нь адилхнаар ч юм уу, тэгж утгаар нь бас биш ээ. Үүнийг нь бол янз янзаар тогтоох ёстой юм байгаа юм. Энэ нь бол ажлын хэсэг дээр сая Тогтохсүрэн дарга хэллээ, бид нар янзлаад дэлгэрүүлээд залруулж болно оо. Залруулах гарцаагүй шаардлагатай асуудал байгаа юм. Тэгэхээр хөрөнгө мөнгөтэй асуудал мэдээж чухал. Тэгээд энэ хуулийн нэг онцлог нь бол бид нар ажлын хэсэг дээр ярьж байсан шүү дээ, Батзандан гишүүн ээ, ерөөсөө нийтлэг зүйлсийн дараа 2 дугаар бүлэг буюу хамгийн гол амин сүнс нь болгож засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүүгийн асуудлуудыг тусгаж өгсөн. Энэ дотроо жишээ нь 15.1 дээр хамгийн эхний өгүүлбэр нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндсийг бүрдүүлэх нь төрийн үүрэг мөн гэж орж ирж байгаа юм. Энэ бол маш чухал заалт. Төр өөр дээрээ хүлээж байгаа том үүрэг хариуцлага. Улсын Их Хурлаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндсийг бүрдүүлэхэд оруулж байгаа том хувь нэмэр гэж бид нар ойлгож байгаа юм. Төртэйгөө хамтарна, төр энэ үүргийг гүйцэтгэнэ. Тэгэхдээ гүйцэтгэхдээ төр энэхүү үүргээ хэрэгжүүлэхдээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дараах эрхийн баталгааг хангана гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл ийм ийм эрхийн баталгааг хангаж байж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс бүрдлээ гэж бид нар үзэх юм байгаа юм.

Тэгээд энд бол мэдээж аймаг, нийслэл, сум, дүүрэг нь бие даасан төсөвтэй байна, эрх мэдлээ шилжүүлж авна, эрх мэдлийг шилжүүлж авахад заавал дагалдах тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө мөнгийг хамт тусгасан байна, төсвийн тухай хуульд зааснаас бусад бие даасан сантай байж болн сангаа захиран зарцуулах эрх нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт нь өөрт нь бүрэн шилжиж байна, аймаг, сум, нийслэл, дүүрэг нь өмчтэй байна, өмчийг нь бол дотор нь ангилаад нийтийн зориулалттай, өөрийн өмчөөс гээд тэгээд өмчийг захиран зарцуулах үндсэн сууриудыг нь тавьж өгч байна. Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хуулийн этгээд байгуулах эрхтэй гэдгийг нь зааж өглөө. Мөн энэ хуулийн нэг чухал заалт бол аймаг, нийслэл, сум, баг, дүүрэг, хороо нийтийн эрх зүйн этгээд байна. Иргэний хуульд заасан байсан аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно гэдгийг бид нар энэ нэгжийнхээ тухай хуульд зааж өглөө. Энэ заалтуудаар бол аймаг, нийслэл, сум, дүүрэг нь бие даасан хуулийн этгээд буюу нийтийн эрх зүйн этгээдийнхээ хүрээнд гэрээ, хэлцэл байгуулж байдаг. Гэрээнийхээ дагуу үүрэг хүлээж байдаг. Эрх эдэлж байдаг. Өмчөө захиран зарцуулах эрх нь баталгаажиг байгаа олон дэвшилтүүд байгаа.

Тэгээд энэ би Байнгын хорооны гишүүдийгээ энэ 3 дугаар бүлэгт гол анхаарлаа бас хандуулаарай гэж хүсмээр байгаа юм аа. 3 дугаар бүлэгт бол орон нутгийн чиг үүргийг зааж өгсөн байгаа юм аа. Орон нутгийн чиг үүрэг тогтоох зарчим, орон нутгийн чиг үүрэг гээд. Өөрөөр хэлбэл энэ орон нутгийн чиг үүрэг шүү, энэ төрийн чиг үүрэг шүү гэдгийг бид нар одоо хуульчилж ялгаа зааг нь гаргаж өгч байгаа юм аа. Энэ бол их чухал заалт. Орон нутаг энийг хийнэ, төр

энийг хийнэ. Орон нутагт хийхдээ шат шатандаа энэ шатандаа энэ нь ийм үүрэг чиг үүрэгтэй, дараах шатандаа ийм чиг үүрэгтэй гэдэг нь зааглаж өгч байгаа ач холбогдолтой шинэлэг зүйлүүд их орсон. Тэгээд мэдээж төгс төгөлдөр биш ... /минут дуусав/

**С.Бямбацогт:** За Болд гишүүн асуултаа асууя.

**Л.Болд:** За баярлалаа. Тэгэхлээр энэ болбол үнэхээр ард иргэдэд хамгийн их үйлчлэл нөлөөтэй маш чухал хууль орж ирж байгаа юм л даа. Тэгээд энэ хуулийг санаачлагчдаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид олон зүйлийг засах гэж оролдсон. Тэр бүгдийгээ одоо ард иргэд ойлгомжтой засаж чадсан гээд тийм бүрэн итгэлтэйгээр тайлбарлах нь зүйд нийцнэ л дээ. Тухайлбал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үед бид ямар асуудал нэлээд их яригдсан гэхлээр энэ иргэдийн хурлыг иргэдэд нь өгье өө, иргэдийн хурлын түвшинд энэ намчирхал болбол үнэхээр орон нутгийн одоо хогоо цэвэрлэх гэхэд л 2 талын, 3 талын намын тэмцэл болдог, эргээд засаглаж чаддаггүй, эргээд ард иргэд хохирдог. Тэгээд орон нутгийн түвшинд болбол тэр улс төржилт, улс төрийн намчирхал бол ерөөсөө огт байж болохгүй зүйл гэдгийг одоо тийм ээ тэр чинь иргэдийн өдөр тутмын л зовлон зүдүүрийг шийдэх гэж байгаа тэр түвшний хурал дээр. Тэгэхээр энийгээ энд аль түвшинд нь, яаж хийж чадсан бэ. Энэ өөрөө бол ард түмэн бол маш тодорхой ойлголтыг эндээс бол хүсэж байгаа.

Бид бүхэнд маш тодорхой жишээнүүд байна тийм ээ, Сүхбаатар аймагт юу боллоо, Баянзүрх дүүрэгт юу болж байгаа билээ гэхчлэн дээр одоо энэ асуудлууд дахиж гарахгүй гэх баталгаа байна уу. Тухайлбал Баянзүрх дүүрэг шиг ингээд 2 хуваагдчихаад 4 жил иргэдийн хурал нь хуралдаж чадахгүй, үндсэндээ засаг захиргаагүй тэр бүх ард иргэд, аж ахуйн нэгжүүд бол үнэхээр аймшигтай хохирч байгаа шүү дээ. Энэ болбол үнэхээр Монголын төр яачхав аа гээд тэнд бол та нар очиход бол үнэхээр нөхцөл байдал бол маш хүнд байгаа шүү дээ. Энэ мэтчилэнгээр ч аймаг, сум, дүүргүүд бол өшөө бий л дээ. Маш олон хороод байна, манай Хан-Уул дүүргийн нийт хороодын 60 хувь нь засаг захиргаа дээр болбол маргаантай. Дандаа үүрэг гүйцэтгэгч нар. Үнэхээр тэнд бол ажиллах ямар ч нөхцөлд ард иргэд бол үнэхээр цөхрөнгөө харж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бүгдийг шийдэж чадсан уу гэдэг л асуудал байна л даа. Ер нь тэгээд засаг дарга нарын асуудлыг бид Үндсэн хуульдаа маш их ярьсан. Ард түмнээ сонгоод энэ холбооны улс шиг болбол баларна энийг зогсооё гэж бид нар асуудлыг болбол зөв зохистой шийдсэн. Одоо тэгээд энэ засаг дарга чинь яг хуулийн дагуу хүмүүс томилогдоод л яг хуулийн дагуу ажиллах тэр нөхцөл бололцоо нь баталгаанд бий болж чадаж байна уу, үгүй юу тийм ээ. Тэгээд урьд нь одоо төрийн албанд 3 жил хаасан байх ёстой гээд л нөхцөл байж л байсан, тэрийг тэгээд их олон тохиолдолд зөрчиж байсан. Тэгээд л яах вэ дээ зөрчөөд л ингээд л заргалдаж явсаар байгаад л ингээд хууль зөрчигдөөд л хууль одоо хэрэгжихгүй явсаар байгаад л ингээд зүгээр амьдрал дээр бол маш тийм тодорхой зөрчилтэй асуудлууд тэр чигээрээ явчихдаг. Тэгэхээр энэ бүгдийг өнөөдөр засах талаар ШИНЭ намаас Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн явцад бол маш олон санал гаргаж байсан нэлээд нь дэмжигдсэн гэхдээ дараа дараагийн хуулиар засна аа гэдэг ийм амлалттайгаар болбол зөвшилцөөд явсан шүү дээ. Тэгэхлээр энэ бүгдийг энэ хуульд тусгаж чадсан уу гэдгийг одоо нэг ойлгомжтой хэлж өгөөч ээ.

**С.Бямбацогт:** За баярлалаа, Тогтохсүрэн гишүүн хууль санаачлагч хариулъя.

**Д.Тогтохсүрэн:** Энэ их олон удаа ярьдаг чухал асуудал байгаа юм аа. Би шууд шууд хариулаад явчихъя аа.

Хуулийн төсөлд суманд сумын иргэдийн хуралд улс төрийн нам нэр дэвшүүлэхээ хориглоно оо гээд орчихсон. Тийм учраас суманд бол бид нар улс төржилт байхгүй болох чиглэлд хийгдэж байгаа. Нөгөө талаар аймаг, нийслэл, дүүрэгт иргэдийн хуралд бүлэг байгуулахыг хориглоно оо гэж байгаа юм, улс төрийн намууд.

Сум, аймаг, дүүргийн хурал болбол шууд сонгуулиар явна аа. Нийслэлийн хурал бол дүүргээс сонгогдоно оо гэж хуулийн төсөлд тусгагдсан байгаа. Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг хариуцлагажуулах олон заалт бий, төлөөлөгчдийг эгүүлэн татахаас эхлээд. Иргэдийн хурлыг тараах заалт орж ирсэн. Энэ тарах заалт нь аймаг, нийслэлийн, засаг даргын саналыг үндэслэж Засгийн газар тараахаар оруулж ирж байгаа. Хурлыг. За иргэдийн төлөөлөгчдийн хурлуудад хариуцлагажуулж тодорхой юмнууд, ямар тохиолдолд тарах вэ гэдгийг нь тодорхойлж өгч байгаа. Засаг даргадаа нэр дэвшүүлж чадахгүй бол, жишээлбэл анхдугаар хуралдаанаа хийж Засаг даргадаа 50 хоногийн дотор нэр дэвшүүлж чадахгүй болбол тараана аа гэж байгаа юм. Төсвөө хугацаанд нь баталж чадахгүй бол тараана аа гэж байгаа юм. Ингээд болбол тарах ийм заалтыг болбол тодорхой болгож өгсөн.

Засаг даргын тухайд бол ийм болсон. Үндсэн хуульд бол заавал иргэдийн төлөөлөгчдийн хурал нэр дэвшүүлнэ гээд заачихсан. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн нийтийн хуралд. Тэр нэр дэвшсэн хүнийг дээд шатны засаг дарга юм уу, ерөнхий сайд томилохоор Үндсэн хуульд байгаа юм аа. Тэгэхээр одоо бол ямар оролцоог бий болгосон гэхээр багийн даргат, сумын засаг даргат аймгийн засаг даргад дээд шатных нь засаг дарга юм уу, ерөнхий сайд нэр дэвшилтэд нь оролцдог тийм зүйлийг энэ хуулиар оруулж өгч байгаа. Өөрөөр хэлбэл санал болгодог. Иргэдийн хурлын төлөөлөгчдөө өөрсдөө засаг даргадаа санал болгоно, дээд шатны засаг дарга юм уу, аймгийн засаг дарга юм уу, Ерөнхий сайд санал болгодог. Багийн иргэдийн хурал бол сумын засаг дарга санал болгодог ийм санал болгодог одоо ийм зүйлийг оруулж өгсөн. Энэ болбол би түрүүн хэлсэн нэгдмэл улсын хувьд засаг төрийн төлөөлөгчөө томилж байгаагийн хувьд, өнөөдөр орон нутагт үүсээд байгаа хүндрэлтэй нөхцөл байдал байдлуудаас гарахын тулд л засаг дарга дээр болбол ийм зүйлийг хуульд одоо шинээр оруулж өгсөн.

**С.Бямбацогт:** За баярлалаа. Санал хэлнэ ээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хэлэлцэх эсэхийг дэмжихтэй холбогдуулан үг хэлье.

Батзандан гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

**Д.Эрдэнэбат:** Баярлалаа. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад босоо тогтолцооны хэлбэрийг оруулж төрийн захиргааны байгууллага ямарваа нэгэн байдлаар нөлөөлөх эрх байхгүй ээ. Төрийн захиргааны байгууллага гүйцэтгэх байгууллагаа нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага сонгодог ийм Үндсэн хуулийн зарчимтай. Энэ зарчим үндсэндээ энэ хуульд бол алдагдсан гэж би ингэж харж байгаа. Би яагаад дэмжихгүй байгаагаа хэдэн зүйлээр л тодорхой хэлчихье гэж.

2 дугаарт энэ хуулиар иргэдийн төлөөлөгчдийн хурал бүрдэхдээ бие даагчдын хэлбэрээр бүрдэж байгаа нь энэ иргэдийн хурлын төлөөлөгч бүрдсэн ч бодлогын хэмжээнд авч явах ийм бүтэц чадавхгүй, зохион байгуулалтгүй иргэдийн хурал болно оо гэж бид харж байгаа. Миний харж байгаа өнцөг энэ. Ийм нэгдсэн зохион байгуулалтгүй энэ иргэдийн хурал орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлоход тун бэрхшээл учирна аа. Харин тарах нь амархан иргэдийн хурал болж магадгүй ээ. Бид нар Үндсэн хуульдаа намын асуудлыг албан ёсны болгож хүлээн зөвшөөрчхөөд, орон нутгийн сонгууль дээр огт намгүй оролцдог гэдэг ийм популист маягийн зүйлийг оруулж ирдэг нь болбол энэ улс төрийнхөө хувьд ч тэр зохион байгуулалтынхаа хувьд ч тэр маш том алдаа болж хувирна. Би бол тэгж харж байгаа.

Дараагийн асуудал. Хэрвээ бид нар энийг үнэхээр орон нутгийн хөгжлийг ярьж байгаа болбол энэ төвлөрсөн байдлаасаа, хэт төвлөрлөөсөө салах хэрэгтэй. Бүх татварын эрх зөвхөн 331 сум, дүүргээс эхэлнэ ээ. Тэнд аймаг хамаа байхгүй Засгийн газар хамаа байхгүй, өнөөдрийн энэ үүсээд байгаа төвлөрөл чинь бүгдээрээ Их Хурлын гишүүн болохыг хүсдэг, бүгдээрээ нэгдсэн төсөв рүү орж давхиж орж нэгдсэн юм руу хувь хүртэхийг хүсэгчдийн ийм гаж тогтолцоо руу бид нар давхиж орсон. Энэнээсээ болж байж сумын хөгжил, орон нутгийн хөгжлийн тухай, орон нутгийн иргэдийн амьдралын тухай асуудал бол үндсэндээ бол хаягдсан.

Улсаа хөгжүүлэе гэж байгаа болбол 331 сум, 9 дүүргээсээ бид эхлэх ёстой. Энэ хөгжил эндээс эхлэх ёстой гэж би харж байгаа. Иргэдийнхээ тэр анхан шатны нутаг дэвсгэрт амьдарч байгаа иргэдийнхээ нийгмийн баталгааг хангаж чадахгүй байж байж, тэнд байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулах эрх мэдэлгүй байж байж, эдийн засгийн санхүүгийн эрх мэдэлгүй байж байж бид энэ хөгжлийн тухай хоосон яриа болбол ярьж болохгүй ээ. Тийм учраас ийм хуулийн өөрчлөлтийг бид нар хүсэж байгаа. Би ийм хууль болоосой гэж хүссэн чинь харамсалтай нь энэ ийм байдлаар орж ирээгүй. Аймаг гэдэг нэг давхар бүтцийг бид нар эргэж харах ёстой. Аймаг болбол зөвхөн хөгжил төлөвлөлтийн бодлогыг ярихаас биш ийм давхар нутаг дэвсгэрийн нэгжийн 1 ийм бүтэц байгаад давхар татвар хураадаг давхар данхар оронтой бүтэцтэй байдаг нь болбол зарчмын хувьд буруу гэж би Үндсэн хууль хэлэлцэх үед хэлж байсан. Харамсалтай нь энэ болбол яваагүй ээ, тийм учраас болбол энэ хуулийг болбол зарчим нь буруу болсон, маш буруу зарчим руу орсон. Орон нутгийн хөгжил иргэдийн сайн сайхны төлөө гэсэн үндсэн зорилгоосоо гажсан, энийг тодорхой болгож чадаагүй учраас би энэ хуулийн төсөлд оролцохгүй ээ гэдгээ би илэрхийлж байгаа. Энэнээс гарах сөрөг үр дагаврууд энэ хуулийг хэрэгжсэн өдрөөс эхэлж гарна аа гэдгийг би маш сайн мэдэж байна аа. Тийм учраас энэ хуулийн төслөө болохгүй бол эргүүлэн татаж байгаад эргэж нэг хар аа. Ийм байдлаар энэ хууль батлагдах юм болбол дараа нь орон нутгийн одоо улсыг хамарсан, нутаг дэвсгэр бүхэлд нь хамарсан том маргаантай сэдэв рүү бид гулсан орох болж байна шүү гэдгийг би гишүүддээ анхааруулж хэлье, баярлалаа.

**С.Бямбацогт:** Батзандан гишүүн гишүүн саналаа хэлье.

**Ж.Батзандан:** За хувь хүний орлогын албан татвар, газрын төлбөрийн 60 хувь үл хөдлөх хөрөнгийн албан татвар, галт зэвсгийн албан татвар гээд сум, дүүргийн төсөвт төсвийн орлогыг бүрдүүлэх татвар хураамжийг хуулиар маш тодорхой зааж өгсөн байгаа. Энэ ажлын хэсгээс би тодорхой зүйл асууя аа. Яг энэ

хууль батлагдан гарснаар Баянзүрх дүүргийн төсвийн орлого хэдэн хувиар нэмэгдэж байна вэ, тодорхой сумууд дээр жишээ авъя. Монгол Улс 330 гаруй сумтай байгаа, сумдын төсвийн орлого хэдэн хувиар нэмэгдэнэ гэж та бүхэн харж байна вэ, энэ дээ надад нэг тийм тодорхой жишээ, судалгаа хэлж өгөөч ээ гэж хүсэж байна.

2 дахь асуудал, авлига албан тушаалтай тэмцэх бодлого энэ хуульд тусгагдах ёстой гэж бид харж байгаа. Орон нутгийн засаг дарга нар цагдаагийн дарга аа, татварын дарга аа, аймаг орон нутгийнхаа прокуроруудад газар өгөх маягаар, давуу байдал үүсгэх маягаар авлигын сүлжээ үүсгэдэг олон арван жилийн туршлага бий болсон. Энэ засаг дарга нарын авлига албан тушаалын гэмт хэргийг яаж энэ хуулиар хязгаарлахаар, засаг дарга нарын үйл ажиллагаанд хориглох зүйлийг иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт хориглох үйл ажиллагаа хуульд тусгайлан зааж өгсөн үү гэдэг дээр ажлын хэсэг анхаараарай. Ажлын хэсэгт ШИНЭ нам орж ажиллаж байгаа учраас энэ чиглэлд бид тодорхой зүйлүүдийг та бүхнээс асууна аа.

3 дугаар асуудал. Зөвхөн суманд сумын иргэдийн хурлын сонгуульд нам оролцохыг хориглоно оо гэдэг заалт оруулсан байна аа. ШИНЭ намын ШИНЭ эвслийн санал бол бүх шатны иргэдийн хурлын сонгуульд улс төрийн намын оролцоог хориглож байгаа. Хориглох санал гаргаж байгаа. Иргэдийн хурлыг намуудын савраас салгаж, иргэдийн хурлыг иргэдэд нь өгье гэдэг саналыг ШИНЭ эвслээс, ШИНЭ намаас гаргаж байгаа. Намчирхал талцлыг орон нутгийн түвшинд зогсоох ёстой гэдэг байр суурьтай байгаа.

Ажлын хэсгийн оруулж ирсэн 1 саналыг бүрэн дэмжиж байгаа. Орон нутгийн иргэдийн хуралд бүлэг байгуулахыг бүрэн хориглосон энэ саналыг бол бид дэмжиж байгаагаа илэрхийлье ээ. Ингээд ажлын хэсэгт амжилт хүсье. ШИНЭ намаас гаргасан саналуудад хүндэтгэлтэй хандаж, бие биеэ ойлгож энэ хуулийг яаралтай батлан гаргах нь зүйтэй гэдэг байр суурьтай байгаа илэрхийлье ээ.

**С.Бямбацогт:** За баярлалаа. Гишүүд асуулт асууж хуулийн төсөлдөө болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар уг санал дэмжигдэж байна аа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийг сүүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Хаянхярваа гишүүн танилцуулчих уу.

За Хаянхярваа гишүүн танилцуулъя.